



НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 07 сарын 30 өдөр

Дугаар Ү/47

Улаанбаатар хот

Д.Жаргалсайханыг ажилд томилох тухай

Монгол Улсын "Төрийн албаны тухай" хууийн 10 дугаар зүйлийн 10.1 дэхь заалт, 17-р зүйлийн 17.1 дэхь заалт, 18 зүйлийн 18.1 дэхь заалт, "Төсвийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.5 дахь заалтууд, Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 190 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2013 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/45 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. Дашдондог овогтой Жаргалсайханыг "Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн" албан тушаалд 2013 оны 08 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн нэг жилийн туршилтын хугацаагаар томилон ажиллуулсугай.

2. Д.Жаргалсайханы сарын үндсэн цалинг Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 78-р тогтоолоор батлагдсан цалингийн сүлжээний дагуу /ТЗ-5-5/ 546,386 /таван зуун дөчин зургаан мянга гурван зуун наян зургаа/ төгрөгөөр цалинжуулж, холбогдох журмын дагуу унаа, хоолны хөнгөлөлтийг олгохыг нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

3. Д.Жаргалсайханы ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэн ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс /Ц.Цог/ -т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.БАТСАЙХАН

My documents tushaal

1150501003